Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 13 дугаар тогтоолын хавсралт

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерийн программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

## НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

| Д/д | Шалгуур үзүүлэлт |
|---|---|
| **1.1** | **Эцэг/эхийн нэр:** Дамиран<br>**Нэр:** Сувдаа |
| **1.2** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал**<br>▪ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүн |
| **1.3** | **Иргэний харьяалал**<br>Монгол Улсын иргэн мөн эсэх /**тийм**, эсхүл үгүй гэж бичих/ **Тийм.**<br>Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл **үгүй** гэж бичих/. **Үгүй** |
| **1.4** | **Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх:**<br>-эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;<br>▪ Эдийн засгийн ухааны доктор /PhD/<br>▪ Санхүүгийн шинжлэх ухааны магистр /Master of Economics in Finance/<br>-сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх;<br>▪ Ямар нэгэн улс төрийн намын гишүүнчлэлгүй<br>▪ Улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй<br>-зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;<br>▪ Ямар нэгэн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй<br>-хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;<br>▪ Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх зүйл байхгүй<br>*-эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ.*<br>• албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа<br>▪ 1994 оноос МУИС-ийн Бизнесийн сургуулийн (хуучнаар Эдийн засгийн сургууль) Санхүүгийн тэнхимд Багш, Ахлах багш, Дэд профессор, Профессорын албан тушаалд, 30 дахь хичээлийн жилдээ багшилж байна.<br>▪ 1988-1990 онд Увс аймгийн банкны конторт хянагч нягтлан бодогчоор ажилласан |

| | |
|---|---|
| | • эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.<br>▪ Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн тоо нийт 32, ***үүнээс 24 илтгэлийг Төсөв, татварын асуудлаар хэлэлцүүлсэн байна.***<br>▪ Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо нийт- 49. ***Үүнээс: 38 өгүүлэл нь Төсөв, Татварын сэдвээр хэвлүүлсэн өгүүлэл байна.***<br>▪ Web of Science IF-JCR индекс бүхий сэтгүүл болон Scopus CiteScore бүхий сэтгүүлүүдэд сүүлийн 5 жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо - 2<br>▪ Мэргэжлийн түвшинд хянагддаг (peer review хийгддэг) олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд-13 өгүүлэл тус тус нийтлүүлсэн.<br>▪ Нотлох баримт: ***Бүтээлийн жагсаалт*** болон ***нийтлэлийн хуулбар*** хавсаргав. |
| 1.5 | **Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар**<br>Хүсэлт гаргагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>▪ “Хувь хүний орлогын албан татвар ногдуулалтыг сайжруулах нь” сэдвээр *Эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан*,Монгол Улс, МУИС, 2013 он<br>▪ Фредерих С.Мишкин, Стэнли Г. Иэкинс "Санхүүгийн зах зээл ба байгууллагууд”, 9 дэх хэвлэлт,Pearson Global Edition,*Сурах бичгийн орчуулгын редактор, орчуулагч, хамтын бүтээл,* МУИС Пресс, 2022 он<br>▪ Нийт 9 ном сурах бичиг, гарын авлага бичиж; 4 сурах бичгийн редактороор ажилласан.<br>▪ Төсөв, татвар болон Төрийн санхүү, Бизнесийн удирдлагын чиглэлээр нийт-18 улсын болон гэрээт, захиалгат төслүүдэд оролцсон. Үүнээс сүүлийн 5 жилд 7 төслийн удирдагчаар ажилласан. Үүнд 2018-2019 онд БСШУЯ, Шинжлэх Ухаан Технологийн Сангийн санхүүжилттэй ***“Татварын бодлого, багц хуулийн шинэчлэл эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа”*** сэдэвт Сангийн Яамны захиалгат төслийн удирдагчаар ажиллаж 2020 онд амжилттай хүлээлгэж өгсөн.<br>▪ *Education Financing and Investment Expert;* ADB, National Education Survey for Development of Education Sector Master Plan, From March to August, 2019, Mongolia<br>▪ “Групп компанийн үнэ шилжилтэд тулгамдаж буй асуудал: судалгаа, үр дүн” сэдвээр МУИС, Бизнесийн сургуулийн дотоод төслийг 2021 оны 12 сараас эхлэн удирдаж байгаа, төлсийн ажил одоогоор үргэлжилж байна.<br>▪ “Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангах боломж” төслийн удирдагчаар ажиллаж хүлээлгэж өгсөн. Захиалагч УИХТГ, ТТБЗ, 2020 он<br>▪ Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн тоо 32. ***Эдгээрээс 24 илтгэл нь Төсөв, татвартай холбоотой асуудлаар хэлэлцүүлсэн байна.***<br>▪ Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо **нийт- 49. *Үүнээс: 38 өгүүлэл нь Төсөв, Татварын сэдвээр хэвлүүлсэн өгүүлэл байна.***<br>▪ Web of Science IF-JCR индекс бүхий сэтгүүл болон Scopus CiteScore бүхий сэтгүүлүүдэд сүүлийн 5 жилд хэвлүүлсэн өгүүллийн тоо -2<br>▪ Мэргэжлийн түвшинд хянагддаг (peer review хийгддэг) олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд-13 өгүүлэл тус тус нийтлүүлсэн.<br><br>***-үйл ажиллагааны гол агуулга;*** |

| | |
|---|---|
| | ▪ Профессор Д.Сувдаагийн эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлын үндсэн чиглэл нь<br>o Төрийн санхүү: Төсөв, татвар<br>o Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал болон Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүжилт, түүний үр өгөөж<br>o ЖДҮ-ийн хөгжил, санхүүжилтийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж ирсэн<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>▪ Гадаад, дотоодын ЭШ-ний хуралд оролцож, илтгэл тавьж хэлэлцүүлэх<br>▪ WoS, Scopus Indexed болон мэргэжлийн түвшинд хянан магадлагаа хийгддэг ОУ-ын ЭШ-ний сэтгүүл болон дотоодын ЭШ-ний сэтгүүлд өгүүлэл нийтлэх<br>▪ Төрийн санхүү болон төсөв, татварын чиглэлээр зөвлөх, экспертээр ажиллах<br>▪ Гадаад, дотоодын захиалгат,гэрээт төсөл удирдах, төсөлд оролцох |
| 1.6 | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Эдийн засаг,төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.<br>▪ Монголын Санхүүчдийн Нийгэмлэг НҮТББ-ын гишүүн, 1997 оноос<br>▪ Монголын Санхүүгийн Академи НҮТББ-ын гишүүн, 2000 оноос<br><br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноо<br>▪ 2017 оноос Санхүүгийн багш нарын нийгэмлэг НҮТББ-ын гүйцэтгэх захирал,<br>▪ 2018 оноос Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн<br>▪ |
| 1.7 | **Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл** |

**Ном сурах бичиг**

| Ном сурах бичгийн нэр | Хэвлэгдсэн он | Хэвлэлийн хуудас |
|---|---|---|
| Нэмэгдсэн өртгийн албан татвар /гарын авлага/ | 1999 | 1.1 хх |
| Албан татвар ногдуулалт/сурах бичиг/ Д.Намжил нарынхамтын бүтээл | 2002 | 12.6 хх |
| Татварын онол,тогтолцоо хичээлийн бодлого дасгалын хураамж | 2006, 2012 | 2.3хх |
| Төрийн санхүү хичээлийн бодлого дасгалын хураамж /шинэчилсэн хувилбар/ | 2009, 2015 | 2.5 хх |
| Олон улсын банк санхүүгийн байгууллагууд /оюутны бие даах материал/ | 2008 | 2.3 хх |
| Санхүү-мөнгөний бодлого гарын авлага, Д.Намжил | 2008 | 2.3 хх |
| Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй- номын бүлэг (Татварын ёс зүй), НШУИС багш : Д.Тунгалаг | 2012, Соёмбо принтинг | 2.2 хх |
| Л.Энхмэнд. Санхүү, татварын нэр томъёоны англи-монгол товч тайлбар толь бичгийн редактор | 2013, Соёмбо принтинг | 18 хх |
| “Хувь хүний санхүү” сурах бичгийн редактор | 2016 | 3.25 хх |
| Төрийн санхүүгийн бодлого дасгалын хураамж, Т.Мөнхзаяа хамтарсан | 2020, Тод бичиг ХХК | 3.75 хх |
| Фредерих С.Мишкин, Стэнли Г. Иэкинс "Санхүүгийн зах зээл ба байгууллагууд”, 9 дэх хэвлэлт, Pearson Global Edition, *Сурах бичгийн орчуулгын редактор* | 2022, Соёмбо хэвлэлийн газар | 88 хх |
| Фредерих С.Мишкин, Стэнли Г. Иэкинс "Санхүүгийн зах зээл ба байгууллагууд”, 9 дэх хэвлэлт, Pearson Global Edition, *Сурах бичиг орчуулсан, хамтын бүтээл* | 2022, Соёмбо хэвлэлийн газар | 17.19 хх |
| Д.Нямаа, Х. Минжин *“Групп компанийн орлогын татварын тайлагналын аргазүйн асуудал”,* монограф, редактор | 2023, Нью Индиго ХХК | 8.043 хх |

-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

| | |
|---|---|
| | -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br><br>*-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.* |

| Хаана | Илтгэлийн сэдэв, хэзээ | Хамтарсан илтгэгч |
|---|---|---|
| Бүс нутгийн хөгжил, инноваци, ЭШХ, МУИС, Завхан салбар сургууль | *“Монгол Улсын төсвийн бодлого,* шинэчлэл”, 2018.06.08 Улиастай | Д.Дуламсүрэн |
| Менежмент ба Санхүүгийн орчин үеийн асуудалд сэдэвт Санхүү, Менежментийн тэнхимийн 60 жилийн ойд зориулсан ОУЭШХ | “Монгол Улсын татварын шинэчлэл”, 2018.10.19 | Б.Тэлмүүн , Сангийн яам |
| Татварын онол- практикийн бага хурал, ҮТЕГ | “Татварын бодлого, хэрэгжилтэд тулгарч буй асуудал”. 2018.10.25 | |
| “Обеспечение современного качество в условиях государственного-общественного управления образованием” научно-практическая конференция | “Current issues of financing Higher Educational Institutions of Mongolia”, 14-15 Марта, 2019 | Л.Энхмэнд |
| IFEAMA, 15th Conference on “Innovation Management for the Sustainable and Inclusive Development in a Transforming Asia”, Kyoto University, Japan | “SMEs development and Tax environment in Mongolia”, June, 2019 | |
| Татварын багц хуулийн шинэчлэлийн эдийн засагт үзүүлэх нөлөө, Үндэсний ЭШХ, хамтран зохион байгуулсан МУИС, СЯ, ҮТЕГ | “Татварын шинэчлэл” 2019.11.28 | Н.Баянтөр |
| Санхүүгийн Инноваци сэдэвт XV ОУЭШХ, МУИС, Плехановын нэрэмжит ЭЗИС-ийн УБ салбар хамтарсан хурал | “Tax effects on the attractiveness of Business environment” 2020.12.21 | П.Оюунбилэг |
| International Conference on Business & Management: Global and local Perspectives | “The Some opportunities for improvement of Mongolian Business Environment”, December 17, 2021 | B.Davaasuren<br>D.Suvdaa<br>D.Enkh-Otgon<br>R.Sharbandi |
| МУИС, 80 жилийн ойд зориулсан ЭШХ | “Санхүүгийн тэнхимийн сургалт-судалгааны үр дүн, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр”, 2022.09.28 | Д.Дуламсүрэн |
| The 17th Conference of International Federation of East Asian Management Associations in Hanoi ***Knowledge transformation and Innovation in Global Society: From the perspectives in a transforming Asia***, Hosted by National Economics University of Vietnam 29 March, 2023 | “Tax reform it’s impact on economy: evidence from Mongolia” | П.Оюунбилэг<br>Д.Баярмаа |

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

**Жич:** Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.

. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .

| | |
|---|---|
| 1.8 | **Эрүүгийн хариуцлага**<br>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/ |
| | **Үгүй** |
| 1.9 | **Сахилгын шийтгэлийн талаар**<br>Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх<br>**Үгүй** |

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| | Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/. |
| 2.1 | Миний бие 1994 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүч-эдийн засагч мэргэжлээр төгсөн, тэнхимдээ багшаар үлдэж 30 дахь хичээлийн жилдээ ажиллаж байна.<br>Сүүлийн 30-аад жилийн хугацаанд Төрийн санхүү, төсөв татварын чиглэлээр бакалавр, магистр, докторын оюутнуудад Санхүү мөнгөний бодлого,Төрийн санхүү,Татварын менежмент, Татварын онол,бодлого хичээлүүд зааж, эрдэм шинжилгээ,судалгааны ажил удирдахаас гадна олон улсын байгууллагууд болон дотоодын компаниудтай хамтран гэрээт, захиалгат ажилд төслийн удирдагч, эксперт, зөвлөхөөр тус тус ажиллаж ирлээ.<br><br>Мөн Бизнесийн сургуулийн хөтөлбөр хариуцсан дэд захирал, Санхүүгийн тэнхимийн эрхлэгч зэрэг удирдах албан тушаалд ажиллах хугацаандаа Сангийн Яам, Монгол банк, Татварын Ерөнхий Газар, Гаалийн Ерөнхий газар, Нийгмийн даатгалын Ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Арилжааны банкууд зэрэг дотоодын мэргэжлийн санхүүгийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж Их сургууль болон мэргэжлийн санхүүгийн байгууллагууд хооронд сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллахаас гадна санхүүч, банкир, даатгалын мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагааны гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах ажлыг удирдан зохион байгуулж, цаашид хамтын ажиллагаагаа улам хөгжүүлэхэд анхаарч ажиллаж ирсэн.<br><br>Мөн эрдэмтэн, профессор хүнийхээ хувьд сургалт, судалгааны ажилд оролцохоос гадна олон нийтэд хандсан мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.<br>2017 оноос “Санхүүгийн багш нарын нийгэмлэг” НҮТББ байгуулан *Засгийн газрын худалдан авах ажиллагааны сургалт* (АЗ/тендер) явуулж, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан санхүү, татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж ирлээ.<br>Мөн Монгол Банкны сургалт, судалгааны төвтэй хамтран Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдан “*Сургагч багш”*-ийн гэрчилгээ авсанаар ялангуяа хөдөө орон нутгийн иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэхийг зорьж ажиллаж байна.<br><br>***Мөн 2018 оноос ТТБЗ-ийн хараат бус гишүүн, 2022 оноос Хөгжлийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус ажиллаж байна.***<br><br>Иймд миний бие Төрийн санхүү тэр дундаа төсөв, татварын чиглэлээр мэргэшин ажиллаж ирсэн туршлага, мэдлэг, чадвартаа үндэслэн тухайн албан тушаалд нэр дэвшиж байна.<br><br>***Би хэрвээ энэ хорооны гишүүнээр сонгогдвол дараах гол асуудлуудыг анхаарч ажиллана :***<br><br>- МУ-ын гадаад өрийн асуудал дээр анхаарч ажиллах ба тэр дундаа ЗГ-ын өр дээр анхаарал тавьж ажиллана.<br>- Эдийн засгийн талаас хэмжилтийн алдаа, сүүдэр эдийн засгийг тооцон оруулах тал дээр судлаач, ҮСХ, ЭЗХЯ -тай хамтран ажиллаж нийт макро эдийн засгийнхаа хэмжээг аль болох бодит хэмжээнд нь дөхүүлж байж аливаа загвар, хэжмилт, прогноз хийх тал дээр анхааран ажиллана. |

| | |
|---|---|
| | - Нийт эдийн засгийн хэмжээ, гадаад өр, төсвийн зарцуулалт, төсвийн алдагдал гэсэн гол гол үзүүлэлтийн хэмжээг эдийн засагчид, институциуд, эрхч зүйчид, улс төрчид өөр өөр байдлаар тайлбарлах, пропорц гаргах дээр тайлбарладаг байдлыг аль болох нэг хэмжээсээр тайлбарладаг, ойлгодог болгох тал дээр анхаарч ажиллана.<br>- Төсвийн зарцуулалт нь хувийн секторыг шахан гаргах үзэгдэл нэмэгдэж байгаа тул энэ дээр анхаарч ажиллана. Ингэснээр төсвийн алдагдал багасах, гадаад өрийн дарарт багасах, төрийн эдийн засгийн хэмжээ аль болох оновчтой байх хэрэгтэйг ойлгуулж, хичээж ажиллана.<br>- Мөн төсвийн зарцуулалт, гадаад өр, татварын түвшний талаарх эрх зүйн зохицуулалт нь хэр зохимжтой, оновчтой, эдийн засгийг өсөлтийг хангаж чадахаар байна уу гэдгийг Wagner law, Baumol's law Ratchett effect зэрэг онолын дагуу судлаачидтай хамтран судалж, санал гаргаж УИХ-ын Төсвийн бодлогын байнгын хороонд хүргүүлэх талаар хамтран ажиллана<br>- Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтөд түлхүү анхаарч төсөвлөлтийг орчин үеийн,олон улсын жишиг болон Монгол Улсын онцлогт нийцсэн шинэ арга, аргачлалуудыг (gender based budgeting, performance based-budgeting, program-based budgeting) ашиглан үнэн зөв, бодитой төлөвлөдөг болоход түлхүү анхаарч ажиллана. |

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Дамиран

Өөрийн нэр: . . . . Сувдаа

Гарын үсэг: . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .

Он, сар, өдөр: 2023.12.04

--- oOo ---